БАТЛАВ:
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА Г.ЭНХТАЙВАН

ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ТЕХНИКИЙН БОЛОМЖИЙГ САЙЖРУУЛАХ /ХӨВСГӨЛ АЙМАГ, ТҮНЭЛ СУМ/ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2020.05.12 Дугаар: 2020/4-37 Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	1.1	"Хөвсгөл эрчим хүч" ХХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 59/2020 тоот техникийн нөхцөл
	1.2	Эрчим хүчний сайдын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 102 тоот тушаал
2. Байршил		Хөвсгөл аймаг, Түнэл сум
3. Обьектийн бүрэлдэхүүн, хүч чадал	3.1	Хөвсгөл аймгийн Түнэл сумын төвд гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамжийн техникийн боломжийг сайжруулах
	3.2	АТП-2 дэд өртөөний 0,4 кВ-ын ЦДАШ-ыг бүрэн шинэчилж, төмөр бетон тулгууртай СИП-50 утастай 1,2 км, төмөр бетон тулгууртай СИП-35 утастай 3,3 км татах, 6 тоолуурын багтаамж бүхий тоолуурын шит 32 ширхэгийг бүрэн тоноглож суурилуулах,
	3.3	КТП-5 дэд өртөөнөөс 0,4 кВ-ын гаргалга гаргаж төмөр бетон тулгууртай СИП-50 утастай 1,1 км, төмөр бетон тулгууртай СИП-35 утастай 1,8 км татах, 6 тоолуурын багтаамж бүхий тоолуурын шит 28 ширхэгийг бүрэн тоноглож суурилуулах,
	3.4	АТП-3 дэд өртөөний 0,4 кВ-ын хойд гаргалгааны ЦДАШ-ыг бүрэн шинэчилж, төмөр бетон тулгууртай СИП-50 утастай 0,8 км, төмөр бетон тулгууртай СИП-35 утастай 1,8 км татах, 6 тоолуурын багтаамж бүхий тоолуурын шит 27 ширхэгийг бүрэн тоноглож суурилуулах,
	3.5	0,4 кВ-ын оруулга ба гаргалгаануудыг кабель шугамаар төлөвлөх, кабель шугам нь MNS 6519:2015 стандартын шаардлагыг хангасан, Монгол орны цаг уурын нөхцөл болон галд тэсвэртэй нөхцөлийг хангасан хоолой ашиглаж кабель шугамыг хамгаалах,
	3.6	0,4 кВ-ын ЦДАШ-ын давтан газардуулгыг норм дүрмийн дагуу зураг төсөлд тусгах,
	3.7	Цахилгаан дамжуулах агаарын болон кабель шугам нь MNS 6518:2015, MNS 6519:2015 стандартын шаардлага хангасан байх ба утасны дамжуулагчийн хөндлөн огтлолыг хэрэглээний ачаалал болон хэтийн төлөвтэй уялдуулан тооцоогоор сонгох,

		3.8 10 ба 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур нь MNS:4232-2011 стандартын шаардлагыг хангасан байх, 3.9 Хэрэглэгчийн тоолууруудыг 0,4 кВ-ын ЦДАШ-ын тулгуур дээр нэгдсэн тоолуурын хайрцаганд суурилуулах, щитний газардуулгын зургийг төсөлд тусгах, 3.10 Тоолуурын хайрцагны зураг төсөл нь ашиглагч байгууллагын тавьсан шаардлагыг хангасан байх, 3.11 Хэрэглэгчийн тоолуур нь олон Улсын IEC 62056 цуврал стандартын шаардлагыг хангасан байх ба Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газрын тохирлын гэрчилгээ бүхий, ашиглагч байгууллагын шаардлагыг хангасан байх,
4.	Барилгын үндсэн бүтээц, материал, бусад шаардлага	4.1. Тооцоогоор сонгогдсон тоног төрөөрөмжүүд нь Монгол Улсын болон Олон Улсын Цахилгаан техникийн хорооноос гаргасан стандартуудыг хангасан байх,
5.	Инженерийн хангамж	Техникийн нөхцөлд дурдсан бусад инженерийн хангамж,
6.	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	Нэг үе шаттай, техникийн нөхцлийн хүчинтэй хугацаанд
7.	Цаашид өргөтгөх эсэх	Цаашид өргөтгөх боломжтойгоор зай талбайг тооцож зураг төсөлд тусгах,
8.	Барих хугацаа	2020 он
9.	Гүйцэтгэгч байгууллага	“Эрчим хүчний барилга угсралтын тусгай зөвшөөрөл” авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх,
10.	Захиалагч байгууллага	Эрчим хүчний яам
11.	Зургийн байгууллага	“Эрчим хүчний барилга угсралтын зураг төсөл хийх тусгай зөвшөөрөл” авсан, эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх
12.	Онцгой нөхцөл	12.1.Зураг төслийг Монгол улсын Цахилгаан байгууламжийн дүрэм, Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн мехник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэмийн дагуу гүйцэтгэх 12.2.Зураг төслийг улсын экспертизед оруулахын өмнө ашиглагч байгууллага болон холбогдох газруудаар хянуулж, зөвшөөрөл авсан байх, 12.3.Техникийн нөхцөлд дурдсан бусад шаардлагуудыг зураг төсөлд тусгах,

БОЛОВСРУУЛСАН:
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН
ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ Ш.ГАНЗОРИГ